

## Ионсей Найрамдал эмнэлэг

Улсын Их хурлын 1993 оны 08 дугаар сарын 10-ний өдрийн Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг батлан хэрэгжүүлсний дагуу "БНСУ-ын "Ионсей" их сургуулийн хооронд Засаг даргын тамгын газар, "Ионсей" их сургуулийн 50:50 хувийн хөрөнгө оруулалттай Монгол, Солонгосын хамтарсан эмнэлэг байгуулах гэрээг үсэглэн, эмнэлгийн үйл ажиллагаа эхэлснээр 14 жил болсон.

### **Эрхэм зорилго :**

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын анагаах ухааны шинэ дэвшилтэт техник технологи, оношлог оо боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх улмаар ард иргэдэд стандартын шаардлагад нийцсэн эмчилгээ үйлчилгээ явуулахад чиглэгдэнэ.

**Боловсон хүчин:** Одоогоор Солонгос болон Америк зөвлөх эмч - 6, их эмч-24, сувилагч, дунд мэргэжилтэн-26, бусад ажилчид 18 ажиллаж байна. Тус эмнэлэгт эрдмийн зэрэг цолтой 3, анагаах ухааны магистр -13, мэргэжлийн тэргүүлэх зэрэгтэй эмч -2, ахлах зэрэгтэй-4 их эмч, ахлах зэрэгтэй -1, сувилагч ажиллаж байна.

Боловсролын байдлаар дээд боловсролтой 36 буюу 50,6% тусгай дунд боловсролтой 28 буюу 38,3% бүрэн дунд боловсролтой 6 буюу 8,2%, бүрэн бус дунд боловсролтой 2 буюу 2,7% байгаа нь ажиллагсдын боловсролд тулгуурлах бүрэн боломжтойг харуулж байна.

Эмнэлэг дээд ба дунд мэргэжилтний болон гадаад хэлний / англи, Солонгос/ сургалтыг хуваарийн дагуу хийж, зөвлөх эмч гадаадын мэргэжилтнүүдийг дагалдуулан шавилан сургалтыг тогтмол явуулдаг, Эмч эмнэлгийн дунд мэргэжилтний 80- ас дээш хувь нь БНСУ-д 3 сараас дээш хугацааны мэргэжлийн сургалтад хамрагдсан ба мөн 34 өндөр нарийн мэргэжлийн Солонгос эмч нар ирж ажиллан, эмч, эмнэлгийн дунд мэргэжилтэн дагалдуулан сургасан байна.

Эмнэлэг анх үүсгэн байгуулах үед хүүхэд, шүд, мэс засал, дотор гэсэн 4 мэргэжлийн кабинет ийн 15 эмч, ажиллагсад тайгаар үйл ажиллагаагаа эхэлж байсан. Өнөөдөр төрөлжсөн нарийн мэргэжлийн 10 кабинет, оношлог оо эмчилгээний 9 кабинет нийт 73 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэ хугацаанд төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламжийг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзалгүй улсын хэмжээнд нийт 200000 гаруй хүнд үйлчилсэн байна.

2000 оноос Эмнэлгийн тоног төхөөрөмжийн 70 гаруй хувийг дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын эмнэлгийн үйл ажиллагаанд хэрэглэгддэг орчин үеийн дэвшилтэт техник технологийн шинээр авч нийлүүлэн, эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэж ирсэн нь эмч мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар дээшлэх улмаар үйлчлүүлэгчдэд үзүүлэх эмнэлгийн тусламжийн чанар хүрээ өргөжин байна.

2001 он. 8 сард БНСУ-ийн иргэн чих хамар хоолой, толгой хүзүүний мэс заслын зөвлөх эмч Хан Ён Хүны удирдлага дор чих хамар хоолойн кабинетыг үүсгэн байгуулсан. Солонгос улсын чих хамар хоолойн үзлэгийн 2 иж бүрэн чих хамар хоолойн дурангийн хагалгаа, оношлог оо, эмчилгээ хийх Герман улсын "MG.3 фирмийн дурангийн мэс заслын иж бүрдлийг суурилуулан 38 нэр төрлийн эмчилгээ ба хагалгааг хийж байна.

Хамар дайвар хөндийн архаг үрэвслийн үеийн дурангийн мэс заслын эмчилгээг орчин үеийн төвшинд төгс шийдэж байна.

2001 онд БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага "Койк"-гийн төлөөлөгч, дуран мэс заслын зөвлөх эмч Пан Кван Тэй нь мэс заслын хэвтэн эмчлэх тасгийг шинээр үүсгэн байгуулж, хэвлийн хөндийд дуран хагалгаа хийн зориулалт бүхий тоног төхөөрөмжийн иж бүрдэл суурилуулан хэвлийн хөндийн эмгэгийг дурангаар оношлон, цөсний чулуу болон хурц мухар олгойн дурангийн хагалгаа амжилттай хийж "Монгол улсад анхны "өдрийн мэс засал" /Day Surgery/ ажилбарыг нэвтрүүлсэн. Энэ ажилбар нь хагалгааны үргэлжлэх хугацаа 30-40 минут, эмнэлэгт байх хугацаа 1 хоног, хүндрэл бага байдаг зэрэг нь эмчлүүлэгчдэд сэтгэл зүйн болон эдийн засгийн эерэг үзүүлэлт бүхий онцлог талуудтай юм.Одоогоор 2000 гаруй хүнд дуран хагалгааг амжилттай хийж, 12 Монгол эмч, багш нарыг дагалдуулан сургаж, мэргэшүүлээд байна. Мөн тус кабинетэд гэмтэл согогын нарийн мэргэжлийн эмч ажиллаж ясны хугарал, үе ний мултралд төрөл бүрийн чиг, бэхэлгээг хэрэглэж, түлэнхийн шархыг сорвигүй эдгээдэг мөнгөлөг тосоор, халдварлагдсан шархыг бетантинтай тос, трихополиин холимоогоор эмчилж байна /2008. Зсараас/

Ионсей Найрамдал эмнэлгийн лаборатори нь 1994 онд үйл ажиллагаа эхэлсэн. ба одоогоор 40 гаруй төрлийн шинжилгээг чанарын өндөр төвшинд хийж гүйцэтгэсээр ирлээ.

Кабинетууд нь: Рентген, дурангийн, нөхөн сэргээх,тархины цахилгаан бичлэг,Хэт авианы оношлог ооны кабинет, шүдний кабинет, хиймэл шүдний кабинет. гэх мэт кабинетуудаар клиникийн эмнэлэг болох зорилт тавин ажиллаж байна.